



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Техникийн хорооны бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.12 дахь заалт, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Орон тооны бус техникийн хорооны гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгуур хангасан нэр дэвшигчдийг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын алба /Т.Батмөнх/-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Т.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГАС:



С.ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний
зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын
01.-ний өдрийн 03 тоот тогтоолын

хавсралт

1117149446
ТУ30045.Х.5204703

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ, ТӨЛБӨРИЙН
ХЭМЖЭЭ, ЧАНАРЫН БОЛОН САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН АСУУДЛААР
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ ОРОН ТООНЫ БУС
ТЕХНИКИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус техникийн хорооны /цаашид "техникийн хороо" гэх/ үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Техникийн хороо нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба нь техникийн хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах болон техникийн хорооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

1.4. Техникийн хороо нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, ёс зүйтэй байх, улс төрийн болон бусад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, дүгнэлт, зөвлөмж нь үндэслэл бүхий, шударга, хараат бус байх, албан үүргийн хүрээнд олж авсан мэдээ, мэдээлэл, судалгаа, шинжилгээний нууцлалыг хадгалах, техникийн хорооны үйл ажиллагаатай нийцэхгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх зэрэг зарчмыг баримтална.

**Хоёр. Техникийн хорооны бүрэлдэхүүн, сонгон шалгаруулалтад
тавигдах шаардлага**

2.1. Техникийн хороо нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, чанарын болон санхүүгийн хяналтын асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус 9 гишүүнээс бүрдэнэ.

2.2. Техникийн хорооны орон тооны бус 9 гишүүн нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

2.2.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, чанарын хяналт болон эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, чанарын хяналтын асуудлаар

мэргэшсэн шинжээч, судлаач-3

2.2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ санхүүгийн хяналтын асуудлаар мэргэшсэн санхүүгийн шинжээч, судлаач-2

2.2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөл-2

2.2.4. Даатгуулагчийн эрх ашгийг төлөөлсөн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл-2 гишүүнээс тус тус бүрдэнэ.

2.3. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл журмын 2.2.1-т заасан нэг хүнийг, ажил олгогч, эздийн холбооны төлөөлөл журмын 2.2.3-т заасан нэг хүнийг, Монголын үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл журмын 2.2.4-т заасан нэг хүнийг тус бүр санал болгож, томилуулж болно.

2.4. Техникийн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчид дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1. Монгол Улсын иргэн байх;

2.4.2. Анагаах ухаан, эрүүл мэнд, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, эдийн засаг, даатгал, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан байх;

2.4.3. Эрүүл мэндийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртөг тооцох болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр судалгааны арга зүйн мэдлэгтэй, судалгаа, шинжилгээний ажил хийж байсан туршлагатай, тоон анализ хийх ур чадвартай байх; /Даатгуулагчийн эрх ашгийг төлөөлсөн нэр дэвшигчдэд хамаарахгүй/;

2.4.4. Эрүүл мэндийн удирдлага, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн арга, өртөг тооцох болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр гадаад, дотоодод урт болон богино хугацааны сургалтад хамрагдаж байсан;

2.4.5. Анагаах ухааны нотолгоонд суурилсан олон улсад ашигладаг эмнэл зүйн удирдамжийг ашиглах, тухайн хэлэлцэх асуудлаар олон улсын хүлээн зөвшөөрөгдөхүйц эх сурвалжтай харьцуулах ур чадвартай байх;

2.4.6. Англи хэлний болон компьютерийн өргөн хэрэглээний програм, цахим орчинд ажиллах мэдлэг, чадвартай байх;

2.4.7. Холбогдох асуудалд эрсдэлийн үнэлгээ хийх, өнөөгийн болон ирээдүйн нөлөөллийг нь тодорхойлох, бичиг баримт боловсруулах, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, илтгэх, тайлагнах ур чадвартай байх;

2.4.8. Эрүүл мэндийн даатгалын байгууллагад эмнэлзүйн шинжээчээр

болон даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад ажилладаггүй байх;

2.4.9. Ёсзүйн зөрчил гаргаж байгаагүй, хувийн зохион байгуулалт сайтай, харилцааны өндөр ур чадвартай, багаар ажиллах чадвартай байх;

2.4.10. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

2.5. Техникийн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчид дараах материалыг ажлын албанд ирүүлнэ:

2.5.1. Хувийн хүсэлт;

2.5.2. Төрийн албан хаагчийн анкет;

2.5.3. Иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл иргэний үнэмлэхийн лавлагаа;

2.5.4. Дээд боловсролын диплом, мэргэшлийн үнэмлэх, эрдмийн цол болон мэргэшлийн зэргийн нотлох баримтын хуулбар;

2.5.5. Сургалт, эрдэм шинжилгээний ажлын бүтээл, жагсаалт;

2.5.6. Гадаад, дотоод сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;

2.5.7. Гадаад хэлний мэдлэгтэйг нотлох баримтын хуулбар;

2.5.8. Ёс зүйн салбар хорооны тодорхойлолт;

2.5.9. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ батлагдсан маягтаар илэрхийлсэн мэдэгдэл (Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягт);

2.5.10. И-монголиа цахим системээс нийгмийн даатгалын лавлагаа болон иргэний, эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;

2.5.11. Эрүүл мэндийн байгууллагад ажилладаг нэр дэвшигч тухайн харъяалах байгууллагын удирдлагаас гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн, ур чадварыг тодорхойлсон албан бичиг;

2.5.12. 3*4 хэмжээтэй 2 хувь зураг;

Гурав. Техникийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах, томилох

3.1. Ажлын алба нь орон тооны бус техникийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг нээлттэй зарлаж, зохион байгуулна.

3.2. Техникийн хорооны нарийн бичгийн даргыг ажлын албаны дарга томилж, чөлөөлнө.

3.3. Ажлын алба нь техникийн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын зар, мэдээллийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын вэб, цахим хуудсанд хуанлийн 14 хоногийн хугацаатай

нээлттэй байршуулж, мэдээлнэ.

3.4. Ажлын алба нь нэр дэвшигчдийн баримт бичгийн бүрдлийг хянаж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанд нэр дэвшигч бүрээр танилцуулна.

3.5. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар гишүүд шаардлагатай тохиолдолд нэр дэвшигчдээс асуулт асууж, тайлбар, тодруулга авч, шийдвэрээ гаргана.

3.6. Шалгуур хангасан техникийн хорооны гишүүнд нэр дэвшигчдийг Үндэсний зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар Техникийн хорооны орон тооны бус гишүүнээр 3 жилийн хугацаатай томилно.

3.7. Техникийн хорооны даргыг техникийн хорооны гишүүдийн олонхын саналаар томилно.

3.8. Дараах тохиолдолд техникийн хорооны гишүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлнө.

3.8.1. Дүгнэлт, зөвлөмж гаргуулахаар өгсөн асуудалд 3 ба түүнээс дээш удаа хугацаа хоцроосон буюу дүгнэлт, зөвлөмж гаргаж өгөөгүй, эсхүл техникийн хорооны хуралдаанд 3 ба түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй;

3.8.2. Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

3.8.3. Энэ журмын 4.1, 4.2-т заасан техникийн хорооны гишүүний үүргийг биелүүлээгүй, алдаатай, буруу дүгнэлт гаргасан, ашиг сонирхол, ёс зүйн зөрчил гаргасан, гэмт хэрэгт холбогдсон;

3.8.4. Энэ журмын 2.3-т заасан талууд өөрсдийн санал болгож томилуулсан орон тооны бус гишүүнийг хугацаанаас нь өмнө эгүүлэн татаж болно.

3.9. Техникийн хорооны дарга, гишүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх тухай асуудлыг техникийн хорооны хурлаар хэлэлцэн, саналаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд бичгээр мэдэгдэх ба Үндэсний зөвлөл нь тухайн гишүүнийг хугацаанаас нь өмнө чөлөөлж, энэ журмын 2.4, 2.5-д заасан шаардлага хангасан нэр дэвшигчийг нөхөн томилно.

3.10. Техникийн хорооны гишүүнээр нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа уг албан тушаалаас чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

Дөрөв. Техникийн хорооны дарга, гишүүдийн эрх, үүрэг

4.1. Техникийн хорооны дарга дараах эрх, үүрэгтэй.

4.1.1. Техникийн хорооны дүгнэлт, зөвлөмжийн загварыг батлах;

4.1.2. Техникийн хорооны хурлын тов, хэлэлцүүлэх асуудлын

төлөвлөгөөг батлах;

4.1.3. Техникийн хорооны гишүүдээс журамд заасан хугацаанд дүгнэлт, зөвлөмжийг гаргуулан авах, хурлаар хэлэлцэх;

4.1.4. Техникийн хорооны үйл ажиллагаа болон хурлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих;

4.1.5. Техникийн хорооны гишүүдийг мэдээллээр хангах, бусад гишүүдийн хамт үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцож дүгнэлт, зөвлөмжөө танилцуулах;

4.2. Техникийн хорооны гишүүд нь дараах эрх, үүрэгтэй.

4.2.1. Дүгнэлт, зөвлөмж гаргуулахаар ирүүлсэн асуудлын хүрээнд чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нарийвчилсан тооцоо судалгаа, нэмэлт мэдээ, мэдээллийг эрүүл мэндийн даатгалын байгууллага болон холбогдох байгууллага, даатгуулагчаас гаргуулах;

4.2.2. Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлыг боловсруулсан албан тушаалтан, байгууллага, ажлын хэсэг эсхүл эрх, ашиг нь хөндөгдөж болзошгүй талуудтай уулзаж, дэлгэрэнгүй мэдээлэл авах, мэдээллийн нууцлалыг хадгалах;

4.2.3. Энэ журмын 5.9-т заасан цалин, урамшууллыг авах;

4.2.4. Бие даасан, хараат бус, шударга, үнэн зөв дүгнэлт, зөвлөмж гаргах;

4.2.5. Техникийн хороогоор хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг холбогдох хууль тогтоомж, эмнэлзүйн удирдамж, заавар, стандартын хүрээнд олон талаас нь нарийвчлан судалж, нотолгоонд суурилсан дүгнэлт, зөвлөмжийг баримт нотолгоо, судалгаа, үндэслэл, тайлбарын хамт гаргах;

4.2.6. Техникийн хороо нь эрүүл мэндийн даатгалын байгууллагаас ирүүлсэн асуудлыг хүлээн авснаас хойш дүгнэлт, зөвлөмжөө ажлын 5-7 хоногийн дотор заавал гаргаж, Техникийн хорооны нарийн бичгийн даргад хүргүүлэх;

4.2.7. Техникийн хорооны гишүүд нь дүгнэлт, зөвлөмж гаргах явцад авсан мэдээлэл, дүн шинжилгээ судалгаа, техникийн хороогоор хэлэлцсэн асуудал, шийдвэр болон техникийн хорооны үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг олон нийтэд шууд задруулах, хувийн цахим хаягаар нийтэд мэдээлэх, урвуулан ашиглахыг хориглох;

4.2.8. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой эрсдэлт нөхцөл байдал, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй тохиолдолд Техникийн хорооны даргад мэдэгдэх;

4.3. Техникийн хорооны нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй.

4.3.1. Техникийн хорооны даргын шийдвэрээр техникийн хорооны хурал зарлах;

4.3.2. Техникийн хорооны хурлын өрөө, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, албажуулах;

4.3.3. Техникийн хорооны хуралдаанд саналын эрхгүйгээр оролцох;

4.3.4. Техникийн хорооны гишүүдээр ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлэг бөглүүлэх;

4.3.5. Техникийн хорооны хурлаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэн, дарга, гишүүдээр гарын үсэг зуруулж, танилцуулга бэлтгэн, холбогдох бусад материалын хамт Техникийн хорооны даргад хүргүүлэх;

4.3.6. Техникийн хорооны үйл ажиллагаатай холбоотой албан хэрэг хөтлөлтийг хариуцах, мэдээллийн сан үүсгэх, архивлах;

Тав. Техникийн хорооны чиг үүрэг

5.1. Техникийн хорооны дарга нь техникийн хорооны үнэлгээ хийх хугацаанд техникийн хорооны орон тооны бус гишүүд, нарийн бичгийн даргыг ажиллах нөхцлөөр хангаж ажиллана.

5.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон ажлын алба нь техникийн хорооны хурал зохион байгуулах өрөө, техник, тоног төхөөрөмж, шаардлагатай баримт, мэдээллээр хангана.

5.3. Техникийн хорооны гишүүдийн дүгнэлт, зөвлөмжийг энэ журмын 4.2.6-д заасан хугацаанд батлагдсан маягтын дагуу хугацаанд гаргуулна.

5.4. Техникийн хороо нь шаардлагатай тохиолдолд дараах асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагаас холбогдох чиглэлээр мэргэшсэн албан тушаалтныг техникийн хорооны үнэлгээ хийхэд болон техникийн хорооны хуралд нэмэлтээр оролцуулж болно. Үүнд:

5.4.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллага;

5.4.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бодлого, эмийн бүртгэл, чанарын хяналтын асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллага;

5.4.3. Хүний эмийн зөвлөл;

5.4.4. Холбогдох асуудал хариуцсан мэргэжлийн салбар зөвлөл, тус зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн,;

5.4.5. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага;

5.4.6. Тухайн асуудлаар мэргэшсэн зөвлөх, бусад судлаачид

5.5. Дүгнэлт, зөвлөмжид техникийн хорооны дарга, бүх гишүүд гарын үсэг

зурж, баталгаажуулсан эсэхэд хяналт тавина.

5.6. Техникийн хорооны хурлыг зохион байгуулж, гишүүдийн олонхын саналаар холбогдох баримтыг эцэслэн баталж, Үндэсний зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

5.7. Техникийн хороо нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 11 дүгээр зүйлийн 11.2, 14 дүгээр зүйлийн 14.8.7, 14.9.8, 14.9.10-т заасан асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

5.8. Техникийн хорооны нарийн бичгийн даргад Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2-т заасны дагуу ажил хавсран гүйцэтгэсэн цалин, хөлсийг албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар сар бүр олгоно.

5.9. Техникийн хорооны гишүүдэд дүгнэлт, зөвлөмжийн тоо, техникийн хорооны хурлын оролцоог харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээний урамшууллыг тухай бүрд олгоно.

5.10. Ажлын алба нь жил бүр техникийн хорооны гишүүдийн цалин, урамшууллыг ажлын албаны төсөвт тусгаж, батлуулна.

5.11. Техникийн хороо нь ажлаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд жил бүр тайлагнана